














ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН байдал

Monthly bulletin of **STATISTICS**

2018/12



	Нийгмийн үзүүлэлт	Social indicators	Хуудасны дугаар /Page number/
	Нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгж	Territorial and administrative units	23
	Хүн ам	Population	27
	Хөдөлмөр	Labour	40
	Нийгмийн даатгал, халамж	Social insurance and welfare	43
	Боловсрол	Education	45
	Эрүүл мэнд	Health	47
	Гэмт хэрэг	Crime	50
	Банк	Bank	54
	Төсөв	Budget	57
	Үнэ	Price	64
	Хөдөө аж ахуй	Agriculture	67
	Аж үйлдвэр	Industry	95
	Барилга, дэд бүтэц	Construction, infrastructure	100
	Бизнес регистр	Business register	103
	Бусад	Other	105

Үндсэн үзүүлэлтүүд Basis indicators

Үзүүлэлтүүд Indicators		Хэмжих нэгж	2017	2018	2018/2017
Нийгмийн статистикийн үзүүлэлтүүд - Social indicators					
Хүн амын тоо Population		тоо	57441	58230	101.4
Өрхийн тоо Number of households		тоо	16494	16711	101.3
Бүтэн өнчин хүүхдийн тоо Double orphan children		тоо	51	54	105.9
Хагас өнчин хүүхдийн тоо Half orphan children		тоо	969	995	102.7
Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо Mothers who head households		тоо	2539	2401	94.6
Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо Number of disabled people		тоо	2189	2789	127.4
Хүн амын амжиргааны доод түвшин Minimum subsistence level of population		мян.төг	166.5	178.0	106.9
Төрсөн хүүхдийн тоо /амьд төрөлт/ Live births		тоо	1221	1286	105.3
Нас баралтын тоо Number of deaths		тоо	292	311	106.5
Эхийн эндэгдэл Maternal mortality		тоо	-	-	0.0
Халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо Incidence of communicable diseases		тоо	785	536	68.3
Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо Registered unemployment		тоо	796	919	115.5
Макро эдийн засгийн статистик үзүүлэлтүүд-Macro economic indicators					
Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт Consumer price index		хувь	103.7	107.0	103.2
Татварын орлого Income of tax		сая.төг	6653.4	6775.0	101.8
Аймгийн нэгдсэн төсвийн зарлага Expenditure of budget		сая.төг	53536.1	60221.9	112.5
Нийт малын тоо Number of livestock		толгой	3801651	3513365	92.4
Үүнээс	Адуу Horse	толгой	123689	129999	105.1
	Үхэр Cattle	толгой	85400	85225	99.8
	Тэмээ Camel	толгой	41955	43670	104.1
	Хонь Sheep	толгой	1194602	1057674	88.5
	Ямаа Goat	толгой	2356005	2196797	93.2
Төллөсөн хээлтэгч Number of breeding stock		толгой	1327675	1570848	118.3
Бойжуулсан төл Rearing of young animals		толгой	1304554	1330211	102.0
Мал онд оролт Livestock		хувь	99.1	96.0	96.9
Хорогдсон том мал /бүгд/ Losses of adult animals		толгой	10900	151210	1387.2
Үүнээс	Тэмээ Camel	толгой	87	383	440.2
	Адуу Horse	толгой	311	1977	635.7
	Үхэр Cattle	толгой	286	3367	1177.3
	Хонь Sheep	толгой	3279	36999	1128.4
	Ямаа Goat	толгой	6937	108484	1563.8
Өвчнөөр хорогдсон том мал Losses animals for diseases		толгой	1379	693	50.3
Хээлтэгч малын хорогдол Losses of breeding stock		толгой	1098	27648	2518.0
Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт /бүгд/ Gross industrial output		сая.төг	13450.0	14003.9	104.1
Үүнээс	Цахилгаан Electricity	сая.төг	4821.5	3396.5	70.4
	Дулаан Thermal energy	сая.төг	4713.5	4697.0	99.6
	Усан хангамж Water supply	сая.төг	1450.1	1246.5	86.0
	Боловсруулах үйлдвэр Manufacturing	сая.төг	1197.9	3401.4	283.9
	Олборлох үйлвэрлэл Mining	сая.төг	1267.3	1262.5	99.6

Аргачлалын тайлбар

Хүн ам

Энэ бүлэгт аймгийн хүн амын өсөлт, нас, хүйсийн бүтэц, төрөлт, нас баралт, гэрлэлт, цуцлалт, үрчлэлт зэрэг хүн амын ердийн хөдөлгөөний статистикийн үзүүлэлтийг тусгав.

Хүн амын статистикийн мэдээллийн үндсэн эх үүсвэр нь 10 жил тутамд явуулдаг хүн ам, орон сууцны тооллого, хүн амын ердийн болон шилжих хөдөлгөөний жил бүрийн мэдээ тайлан болно. Аймгийн нутаг дэвсгэрт оршин суугаа хүн ам гэж аймгийн засаг захиргааны нэгжид 183 хоног буюу 6 сараас дээш хугацаагаар оршин сууж байгаа хүн амыг ойлгоно.

Өрх гэж нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс амьдралын наад захын хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг ойлгоно. Өрхийн гишүүд нь хоорондоо ураг төрлийн болон гэр бүлийн хамааралтай эсвэл хамааралгүй байж болно.

Өрх толгойлсон эх гэж нөхөр нь нас барсан, эсвэл сураггүй алга болсон нь шүүхээр тогтоосон, гэрлэлтээ цуцлуулсан, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, гэрлэж байгаагүй боловч төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэдтэй ганц бие эхийг хамруулна.

Эцэг эх нь хоёулаа нас барсан хүүхдийг бүтэн өнчинд, эцэг, эх хоёрын аль нэг нь нас барсан хүүхдийг хагас өнчинд тооцно.

Гэрлэлтэд тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид гэр бүл болсоноо бүртгүүлсэн хүмүүсийг хамруулна.

Цуцлалт нь зохих шатны шүүхээр гэрлэлтээ цуцлуулсныг илэрхийлнэ.

Үрчлэлт гэж үрчлэн авагч нь хүүхэд үрчлэн авсан тухайгаа иргэний гэр бүлийн асуудал эрхэлсэн тухайн шатны албанд бүртгүүлж, гэрчилгээ авсан тохиолдлыг ойлгоно.

Хөдөлмөр

Эдийн засгийн идэвхитэй хүн ам (ажиллах хүч)-д тухайн цаг хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч, нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй иргэдийг хамруулна.

Ажиллагч гэж цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг хэв шинж (статус)-д хамрагдаж буй иргэнийг ойлгоно. Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн долоо хоногт нэгээс дээш цагаар оролцсон иргэдийг ажиллагчдад хамруулна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхитэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хөдөлмөрийн төв бирж, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.

Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал нь иргэн болон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа түр алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжинд байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм. Тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний, ажилгүйдийн даатгал гэсэн төрлөөс нийгмийн даатгал бүрдэнэ.

Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно.

Тэтгэвэр нь даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөгжлийн бэрхшээлтэй болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд (хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл)-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгө байна.

Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

Эрүүл мэнд

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гаргаж авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөд тооцно.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг тодорхойлохдоо тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулна.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох хүүхдийн эндэгдлийг тооцохдоо тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд хуваана.

Эндсэн эхийн тоонд жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөх болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэн эхийг хамааруулна.

Халдварт өвчний өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшинг тооцохдоо тайлант хугацаанд амбулаторийн үзлэгээр шинээр бүртгэгдсэн нийт халдварт өвчний тохиолдлын тоог тухайн хугацааны хүн амын тоонд харьцуулна.

Мөнгө, банк

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгийг банкнаас гадуурх мөнгө болон касс дахь бэлэн мөнгөний нийлбэрээр тооцно.

Бага мөнгө /M1/-ийг банкнаас гадуурх мөнгө болон төгрөгийн харилцах дансан дахь мөнгөний нийлбэрээр тодорхойлно.

Төгрөгийн харилцах дансан дахь мөнгийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төгрөгийн харилцах дансны үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Бараг мөнгийг төгрөгийн болон гадаад валютын хадгаламж, валютын харилцах, цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламжийн сертификатын нийлбэрээр тодорхойлно.

Төгрөг болон валютын хадгаламжийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төгрөг, валютын хадгаламжийн үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Валютын харилцахыг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын валютын харилцах үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Мөнгөний нийлүүлэлт /M2/-ийг банкнаас гадуурх мөнгө, төгрөгийн болон валютын харилцах, хадгаламж, цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламжийн сертификатын нийлбэрээр тооцно. Өөрөөр хэлбэл бага мөнгө болон бараг мөнгөний нийлбэрээр тодорхойлно.

Хэвийн зээл гэж төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно.

Хугацаа хэтэрсэн зээлийг зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлээр тодорхойлно.

Чанаргүй зээлийг хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлээр тооцож гаргана.

Гадаад худалдаа

Гаалийн хорооны статистикт үндэслэн гадаад худалдааны салбарын үндсэн үзүүлэлтийг тооцож байна. Дэлхийн худалдааны байгууллагаас зөвлөмж болгосон “Барааг тодорхойлох, кодлох, уялдуулсан систем”-ийн ангиллын дагуу барааны бүлэг, нэр төрлийг тогтоодог.

Барааны экспорт гэж Монгол Улсын гаалийн нутаг дэвсгэрээс эргэн оруулах үүрэггүйгээр барааг гадаадад гаргахыг ойлгоно.

Барааны экспортод эх орны үйлдвэрлэлийн барааг гадаадад гаргах, мөн реэкспортыг оруулна. Эх орны үйлдвэрлэлийн бараанд мөн түүнчлэн улс оронд оруулсан, дахин боловсруулалт хийсэн, үндсэн чанар буюу техникийн шинжийг өөрчилсөн гадаад гаралтай барааг оруулна.

Барааны реэкспортод Монгол Улсын гаалийн нутаг дэвсгэрт урьд нь оруулсан боловч ямар нэгэн дахин боловсруулалт хийгдээгүй, гаалийн татвар, хураамж болон төлбөргүй, эдийн засгийн хориг хязгаарлалтгүйгээр гадаадад гаргасан барааг оруулна.

Барааны импорт гэж эргүүлж гаргах үүрэггүйгээр Монгол Улсын гаалийн нутаг дэвсгэрт гадаадаас бараа оруулахыг ойлгоно.

Импортод улс орны эдийн засгийн хэрэглээнд зориулж гадаадаас оруулсан бараа, мөн реимпортлох барааг хамруулна. Реимпортын бараанд Монгол Улсын нутаг дэвсгэрээс урьд нь гаргасан хэдий ч эргүүлэн оруулсан барааг оруулна.

Экспорт, импортын нийлбэрээр гадаад худалдааны барааны нийт эргэлтыг тодорхойлно.

Нийт экспортоос импортыг хассан зөрүүгээр тэнцлийг тодорхойлно. Тэнцэл (-) тэмдэгтэй бол алдагдалтай, (+) тэмдэгтэй бол ашигтай гэж үзнэ.

Үнэ

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар өөрчлөгдөж буйг илэрхийлэх үзүүлэлт бөгөөд нэг өрхөөс бус нийт өрхөөр тооцогдсон үнийн дундаж өөрчлөлтийг харуулна.

ХҮИ-ийн тооцоонд хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашигладаг.

Хэрэглээний сагс нь дундаж зарлагатай өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хэрэглээний үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалт юм. Сагсанд сонгогдсон бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тооцоход бараа, үйлчилгээний тоо хэмжээ, төрөл, чанар зэргийг тогтмолоор авч үздэг.

Хэрэглээний бараа үйлчилгээний жин гэж өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувийн жин юм.

ХҮИ-ийн тооцоонд Ласпейресийн үнийн индексийн томъёог ашиглаж байна.

$$I_{ct}^L = \frac{\sum P_{it} Q_{io}}{\sum P_{io} Q_{io}}$$

I_{ct}^L -t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс

t –тайлант үе, 0 – суурь үе,

P_{it} -'i' барааны тайлант үеийн үнэ,

P_{io} -'i' барааны суурь үеийн үнэ,

Q_{io} -'i' барааны суурь үеийн худалдан авсан тоо, хэмжээ,

\sum -нийлбэрийн тэмдэг

Өрхийн нийгэм, эдийн засгийн 2010 оны судалгааны үр дүнгээр хэрэглээний сагсан дахь нэр төрлийг 2011 онд 329 болгон нэмэгдүүлж, (аймгуудад 214 нэр төрөл), хэрэглээний зардлын жинг шинэчилж, 2012 оны 1 дүгээр сараас эхлэн хэрэглээний үнийн индексийг тооцоход ашиглаж байна.

Хөдөө аж ахуйн гол нэрийн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээг сум, аймгийн үнэ цуглуулах нэгжүүдээс сар бүр авч, сарын дундаж үнийг тооцож байна.

Хөдөө аж ахуй

Мал аж ахуй: Малын жил бүрийн тооллого, мөн хашаа худгийн болон бусад тооллого, судалгаа нь мал аж ахуйн салбарын мэдээллийн гол эх үүсвэр юм. Малын тооллогыг зун намрын улиралд буюу ихэвчлэн 8, 9 дүгээр сард явуулж байснаа 1961 оноос мал тэжээвэр амьтдыг жилийн эцэст 12 дугаар сард тоолдог болсон. Энэ хугацаа нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн жилтэй тохирдог, малын орлого зарлагын үзүүлэлт бүрэн гарч дууссан байдаг зэрэг давуу талтай.

Мал тооллогын дүн нь зөвхөн мал, гэрийн тэжээвэр амьтдын тооны өсөлт, бууралтыг харуулах төдийгүй сүргийн нөхөн үйлдвэрлэлийн үзүүлэлтийг тодорхойлж судлах, шинжлэх бололцоог олгоно.

Хөдөө аж ахуйн салбарын боловсон хүчин, ашиглаж байгаа машин, техник, хашаа худгийн тооллогыг 1996 оноос хойш гурван жил тутамд явуулж байна. Манай улсын хувьд мал аж ахуйн гол үйлдвэрлэгчид нь малчдын өрхийн аж ахуй юм. Мал бүхий өрхөд малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэйгээр өсгөн үржүүлдэг өрхийг хамааруулна. Малчин өрх гэж жилийн 4 улирлын туршид малаа малладаг бөгөөд малын ашиг шим тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа өрхийг ойлгоно.

Хээлтэгч малд нас гүйцсэн эм малыг хамруулна. Төл бойжилтын хувийг гаргахдаа бойжуулсан төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

100 эхээс бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж тооцно. Зүй бусаар хорогдсон малын тоонд халдвартай, халдваргүй өвчин, ган, зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг гэнэтийн аюул болон араатан, жигүүртэнд идүүлэх, худаг, хавцалд унах зэрэг хариулга, маллагаатай холбоотой бусад шалтгаанаар хорогдсон малыг хамруулна.

Хүнсэнд хэрэглэсэн малын тоог тооцохдоо оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасна.

Газар тариалан

Газар тариалан эрхэлдэг аж ахуй нэгж, байгууллага, иргэдээс тариалсан талбай, ургацын мэдээг баг, хороод авч сум дүүрэгт нэгтгэж, улмаар аймаг, нийслэлийн статистикийн байгууллагаар дамжин Үндэсний статистикийн хороонд нэгтгэн боловсруулж байна.

Тариалсан талбай гэж хөдөө аж ахуйн ургамал тариалсан талбайг хэлэх бөгөөд тухайн жилд үр суулгасан газрын нийт хэмжээгээр тодорхойлно.

Нийт хураасан ургац нь тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник тосны ургамал зэрэг, таримал ургамлын хэмжээгээр тодорхойлно.

Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарт нийт үйлдвэрлэл нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ. Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-аас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд үндэслэсэн үндэсний ангиллыг мөрдөж байна.

Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг сар бүрийн мэдээлэлд хамруулан судалж, үйлдвэрлэлийн биет хэмжээний индексийг тооцно.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ (2018 оны 12 дугаар сарын байдал)

Хүн ам, нийгмийн зарим үзүүлэлт


Оны эцэст 16.7 мянган өрхөд 58.3 мянган хүн амьдарч байгаагийн 49.8 хувь буюу 29.0 мянга нь эрэгтэйчүүд, 50.2 хувь буюу 29.3 мянга нь эмэгтэйчүүд байна. Нийт хүн амын 32.5 хувь буюу 18.9 мянга нь аймгийн төв Алтай хотод амьдарч байна.

Аймгийн дүнгээр бүтэн өнчин 54, хагас өнчин 995 хүүхэд, арван найм хүртэлх насны хүүхэдтэй гэр бүлгүй хүн 1161, ганц бие өндөр настан өрх 1261, өрх толгойлсон эцэг, эхийн тоо 2944, хөгжлийн бэрхшээлтэй 2789 хүн тус тус байна. Нийт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 18.5 хувь нь хөдөлгөөний согогтой, 9.0 хувь нь сонсгол, 3.4 хувь нь хэл ярианы согогтой, 3.5 хувь нь хавсарсан согогтой, 9.0 хувь нь харах эрхтний өөрчлөлттэй, 43.0 хувь нь бусад, 13.3 хувь нь сэтгэцийн эмгэгтэй хүмүүс байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэн

Аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газарт бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 2018 оны байдлаар 919 байгаагийн 50.3 хувь нь буюу 462 нь эмэгтэйчүүд байна. Эдгээр ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 123 хүнээр буюу 15.4 хувиар өсчээ.

Хөдөлмөр, Халамж үйлчилгээний газарт
бүртгэлтэй ажилгүй иргэд





Бүртгэлтэй ажилгүй иргэдийг боловсролын түвшнээр нь авч үзвэл 226 нь дээд, 46 нь тусгай дунд, 72 нь техник мэргэжлийн, 475 нь бүрэн дунд, 59 нь суурь, 23 нь бага, 18 нь ямар ч боловсролгүй хүмүүс байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэд,
боловсролын түвшнээр, 2018 оны 12
сарын эцэст



Бүртгэлтэй ажилгүй иргэд, насны бүлгээр 2018 оны эхний 12 сарын байдлаар



Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн сангаас 2018 онд 31.1 мянган иргэнд 8 тэрбум 120.8 сая төгрөг олгожээ. Үүнээс нийгмийн халамжийн үйлчилгээний зардалд 4 тэрбум 380.1, жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж 245.7, алдарт эхийн одонгийн тусламжид 673.4, хүнс тэжээлд 577.7, алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт тусламжид 67.7, ОНОТХҮйлчилгээний зардалд 59.6, насны хишиг 373.1, цалинтай ээж 1 тэрбум 550.9 сая, өрх толгойлсон эцэг эхийн тэтгэмж 112.4 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.


Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын шимтгэлээр 11 тэрбум 523.9 сая төгрөг, тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдлийн санхүүжилтээр 18 тэрбум 127.1 сая төгрөг, бүгд 29 тэрбум 651.0 сая төгрөгийн эх үүсвэр төвлөрүүлж, нийт 7.7 мянган хүнд 27 тэрбум 130.9 сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас 1,6 мянган даатгуулагчид 1 тэрбум 282.6 сая, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын 81.6 сая, ажилгүйдлийн тэтгэмжид бүртгүүлсэн 195 иргэнд 227.6 сая төгрөгийн зардлыг тус тус бүрэн олгожээ.


Ерөнхий боловсрол

Ерөнхий боловсролын 28 сургууль, 29 цэцэрлэгт өсвөр үеийг сурган хүмүүжүүлж байна. Ерөнхий боловсролын сургуулиудад 11.4 мянган сурагч суралцаж, цэцэрлэгт 4.5 мянган хүүхэд хүмүүжиж байна. Энэ хичээлийн жилд нэгдүгээр ангид 1272 хүүхэд элсэн суралцаж байна.

Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчид, жил бүрийн хичээлийн жилд



Ерөнхий боловсролын сургуулийн багш, жил бүрийн хичээлийн жилд



Эрүүл мэнд

Аймгийн хэмжээнд 2018 оны эцэст 1277 эх амаржиж, амьд төрсөн хүүхэд 1286 болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс амаржсан эх 61 буюу 5.0 хувиар, хүүхэд 65-аар буюу 5.3 хувиар тус тус өссөн байна.




Нялхасын эндэгдэл 21 болж, өмнөх оны мөн үеийнхээс 1 тохиолдолоор 5.3 хувиар өсч, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 4 тохиолдол бүртгэгдсэн байна.


1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 16.3 болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.1 пунктээр өссөн, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 19.4 болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.3 пунктээр өссөн байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчид 2018 оны эцэст 536 болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 249 буюу 31.7 хувиар буурчээ. Халдварт өвчлөл буурахад гар хөл амны өвчин өмнөх оны мөн үеэс 77.8 буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчид, жил бүрийн эхний 12 сарын байдлаар



Халдварт өвчний төрлөөр 2018 оны 12 сарын байдлаар




Гэмт хэрэг

Байгууллага, иргэдийн 497.4 сая төгрөгийн өмч хөрөнгөнд хохирол учруулж 203 гэмт хэрэг гарчээ. Эдгээр хэргүүдээс хөнгөн гэмт хэрэг 155 (76.4%), хүнд гэмт хэрэг 48 (23.6%) эзэлж байна.

Гэмт хэргийн төрлөөр авч үзвэл хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 50 (24.6%), хулгайн гэмт хэрэг 49 (24.1%), залилах гэмт хэрэг 45 (22.2%), бусад хэрэг 59 (29.1%), нийт хэргийн 120 (59.1%) нь Есөнбулаг сумд гарсан хэрэг эзэлж байна.


Гэмт хэрэг




Баривчлагдсан хүний тоо 114, өмнөх оны мөн үеэс 26 (18.6%), хүлээн авч шалгасан гомдол, мэдээлэл 1114, өмнөх оны мөн үеэс 248 (18.2%), гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 329 өмнөх оны мөн үеэс 69 (15.0%) тус тус буурсан байна.

Нийт зөрчил 9456 өмнөх оны мөн үеэс 3310 (44.9%), торгуулсан хүн, хуулийн этгээд 9083 өмнөх оны мөн үеэс 3310 (57.3%), тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүний тоо 200 (15%) тус тус өссөн байна.

Гэмт хэргийн хэлбэр тоо 2018



Гэмт хэргийн төрөл хувиар 2018



Банк

Мөнгөний нийлүүлэлт /M2/ 2018 оны 12 дугаар сарын эцэст 109.0 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 29.3 тэрбум төгрөг буюу 36.8 хувиар өсчээ.

Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт, сарын эцэст /сая.төг/

Үзүүлэлт	Хугацаа	
	2017-XII	2018-XII
Мөнгөний нийлүүлэлт M2	79684.1	108999.5
Сарын өөрчлөлт, хувиар	15.1	36.8
Нийт хадгаламж	66746.0	90240.0
Сарын өөрчлөлт, хувиар	13.5	35.2
Төгрөгийн хадгаламж	66627.1	89813.6
Сарын өөрчлөлт, хувиар	15.0	34.8
Валютын хадгаламж	118.9	426.4
Сарын өөрчлөлт, хувиар	-86.3	258.6


Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 1.9 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 279.4 сая төгрөг буюу 14.6 хувиар өсчээ.

Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны 12 дугаар сарын эцэст 123.3 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 25.1 тэрбум төгрөг буюу 25.6 хувиар өсчээ.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны 12 дугаар сарын эцэст 559.1 сая төгрөг болж, өмнөх оноос 137.2 сая төгрөг буюу 32.5 хувиар өсчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.45 хувийг эзэлж байна.

Чанаргүй зээл 2018 оны 12 дугаар сарын эцэст 889.9 сая төгрөг болж өмнөх оноос 307.9 сая төгрөгөөр буурсан байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.7 хувийг эзэлж байна.

Чанаргүй зээл




Төсвийн орлого

Орон нутгийн төсөвт 9.5 тэрбум төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөө 115.8 хувиар, үүнээс татварын орлого 6.8 тэрбум төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөө 106.5 хувиар, татварын бус орлого 771.1 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөө 133.6 хувиар тус тус давуулан биелүүлсэн байна.

Орон нутгийн нийт төсөв өмнөх оны мөн үеэс 848.3 (9.8%) сая төгрөгөөр, татварын орлого өмнөх оны мөн үеэс 121.6 (1.8%) сая төгрөгөөр, татварын бус орлого өмнөх оны мөн үеэс 228.9 (42.2%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Улсын болон орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг бүх сумууд 100.4-135.5 хувиар давуулан биелүүлсэн байна.

Төсвийн орлогын төрөл, мянган төгрөгөөр 2018 оны XII сард




Төсвийн зарлага

Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилтийн 94.5 хувийг санхүүжүүлэв. Үүнд бараа, ажил үйлчилгээний зардлын 98.6%, цалин хөлс, нэмэгдэл урамшууллын төлөвлөгөөний 99.3%, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн 98.0%, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын 99.3%, хангамж, бараа материалын зардлын 98.8%, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын 99.1%, эд хогшил, урсгал засварын зардлын 100.4%, томилолт, зочны зардлын 97.8%, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжын 84.8%, бараа үйлчилгээний бусад зардлын 97.1%, зардал санхүүжилтын их үүсвэр 97.5%, урсгал шилжүүлэгийн 95.3 хувийг тус тус санхүүжүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн байгууллагууд 26.5 сая төгрөгийн авлагатай, 356.4 сая төгрөгийн өглөгтэй ажиллажээ.

Орон нутгийн төсвийн зарлага хувиар



Үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс Говь-Алтай аймгийн хэмжээнд 2018 оны 12 дугаар сард өмнөх сараасаа 0.4 хувь, өмнөх оны жилийн эцсээс 7.0 хувиар өссөн байна.


Ерөнхий индекс 2018 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 0.4 хувиар өсөхөд орон сууц, ус, цахилгаан, түлш бүлгийн индекс 1.8 хувь, бусад бараа, үйлчилгээ бүлгийн индекс 1.8 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИНДЕКС, бүлгээр, 2015=100%

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2018-12 2017-12	2018-12 2018-11
Ерөнхий индекс	100.0	107.0	100.4
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	108.7	100.5
Согтууруулах ундаа, тамхи	3.2	110.9	100.0
Хувцас, бөс бараа, гутал	16.1	101.5	100.1
Орон сууц, ус, цахилгаан, түлш	12.3	104.0	101.8
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	101.5	100.3
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	103.5	100.2
Тээвэр	12.2	112.6	99.7
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	100.9	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	100.2	100.0
Боловсролын үйлчилгээ	4.7	127.4	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	100.0	100.0
Бусад бараа, үйлчилгээ	4.1	102.6	101.8

Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ 2018 оны 12 дугаар сард өмнөх оны жилийн эцсээс 7.0 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, ус 8.7, хувцас, бөс бараа, гутал 10.9, тээвэр 12.6, боловсролын үйлчилгээний индекс 27.4 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.



Хэрэглээний үнийн индекс
(өмнөх оны 12 сар=100)



2018 оны мал тооллогын дүн

Говь-Алтай аймаг 2018 оны жилийн эцсийн мал тооллогоор 3513.4 мянган толгой мал тоологдсоны дотор адуу 130.0 мянга, үхэр 85.2 мянга, тэмээ 43.4 мянга, хонь 1057.7 мянга, ямаа 2196.8 мянган мал тус тус тоологджээ.

МАЛЫН ТОО, 1940-2018 он



Малын тоо өмнөх оноос 288.3 мянган толгой буюу 7.6 хувиар буурчээ. Малын өсөлт, бууралтыг төрлөөр авч үзвэл адуу 6.3 мянган толгой буюу 5.1 хувиар, тэмээ 1.7 мянган толгой буюу 4.0 хувиар өсч, харин үхэр 0.2 мянган толгой буюу 0.2 хувиар, хонь 136.9 мянган толгой буюу 11.5 хувиар, ямаа 159.2 мянган толгой буюу 6.8 хувиар тус тус буурсан байна. Улсад нийт тэмээний тоогоор 3-р байранд, ямааны тоогоор 4-р байранд тус тус оржээ.


Малтай 10.3 мянган өрх байгаагийн 7.1 мянга нь малчин өрх байна. Мөн энэ онд 1000 түүнээс дээш малтай өрхийн тоо 555 болж өнгөрсөн оноос 191 өрхөөр буурчээ.

Мянгат малчдын тоо өмнөх оноос 25.6 хувиар буурч 555 болжээ. Үүний дотор 2001-ээс дээш малтай өрх 23, 1500-2000 малтай өрх 59, 1000-1499 малтай өрх 473 байна.

Малын тоогоор Цогт /287.4 мянган толгой/, Дэлгэр /284.2 мянган толгой/, Эрдэнэ /251.8 мянган толгой/, Тонхил /232.7 мянган толгой/, Халиун /230.7 мянган толгой/ сумд эхний 5 байранд тус тус орсон байна.

Адуун сүргийн тоогоор Тонхил, Хөхморьт, Есөнбулаг, Дэлгэр, Халиун сум, үхэр сүргийн тоогоор Бигэр, Цогт, Халиун, Есөнбулаг, Дэлгэр сум, тэмээн сүргийн тоогоор Төгрөг, Шарга, Халиун, Хөхморьт, Цогт сум, хонин сүргийн тоогоор Тонхил, Дэлгэр, Чандмань, Цогт, Есөнбулаг сум, ямаан сүргийн тоогоор Цогт, Эрдэнэ, Дэлгэр, Цээл, Халиун сум тус тус эхний таван байранд орсон байна.

Мянгат малчдын тоо /сумдаар/



Хээлтэгч мал: Хээлтэгч мал өмнөх оноос 3.7 хувиар өсч, оны эцсийн байдлаар төллөх насны хээлтэгч 1 сая 570.8 мянга болж, нийт малын 44.7 хувийг эзлэж тухайн сүргийн дотор гүү 2.6, үнээ 2.1, ингэ 0.9, эм хонь 31.4, эм ямаа 62.9 хувийг тус тус эзэлж байна.

Нийт төллөх насны хээлтэгчийн 62.8 хувь нь төллөж, үүнээс гүүний 71.0 хувь, үнээний 73.4 хувь, ингэний 50.2 хувь, эм хонины 64.6 хувь, эм ямааны 61.3 хувь нь тус тус төллөсөн байна. Мөн тайлант онд 46.0 мянган хээлтэгч мал хээл хаяж, 480.2 мянган хээлтэгч мал сувайрсан байна.

Малын хорогдол: Жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд 151.2 мянган толгой том мал зүй бусаар хорогдсон ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13.9 дахин их байна. Том малын зүй бусын хорогдлыг малын төрлөөр авч үзвэл адуу 1977, үхэр 3367, тэмээ 383, хонь 36.9 мянга, ямаа 108.5 мянга байна. Нийт хорогдлын 24.5 хувийг хонь, 71.7 хувийг ямаа эзэлж байна.

Малчдын соёл ахуйн зарим үзүүлэлт: Аймгийн нийт малчид жилийн дөрвөн улирлын аясаар нүүдэллэж, бэлчээрийн мал аж ахуйгаа маллах явцад соёл ахуйгаа дээшлүүлсээр ирлээ. Тухайлбал: цахилгааны эх үүсгүүртэй өрх 6.2 мянга, сансрын антеннтай өрх 5.2 мянга, телевизортой өрх 5.5 мянга, радиотой өрх 2.8 мянга, оёдлын машинтай өрх 3.7 мянга байна.


Шинээр гаргасан, засварласан худаг: Энэ онд инженерийн хийцтэй 13, энгийн уурхайн 11, бүгд 24 худаг шинээр гаргаж, 23 худгийг засварлан ашиглажээ.

Малжуулалтын талаар: Энэ онд 289 өрхийг 12.1 мянган толгой малаар малжуулж, энэ арга хэмжээнд олон улсын хөтөлбөр төслөөс 101.4 сая, орон нутгийн төсөв болон бусад эх үүсвэрээс 745.0 сая бүгд 846.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Газар тариалан

Энэ оны эцсийн байдлаар үр тариа 294.1 тн, төмс 1218.9 тн, хүнсний ногоо 695.2 тн, малын тэжээлийн ургамал 1693.4 тонныг тус тус хурааж аваад байна. Мөн 3531.1 тн байгалийн хадлан, 452.8 тн гар тэжээл, 7481.3 тн хужир шүү тус тус бэлтгэсэн байна.

Хураасан ургац, бэлтгэсэн өвс хадлан жил бүрийн эцэст



Аж үйлдвэр


Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2018 оны жилийн эцсийн байдлаар 10.4 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 1.7 тэрбум төгрөг буюу 20 хувиар өслөө. Боловсруулах үйлдвэрийн салбар 2.8 дахин өссөн гол шалтгаан нь мах үйлдвэрлэл нэмэгдсэн нь голлон нөлөөлөв.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл, жил бүрийн эхний 12 сарын байдлаар

Аж үйлдвэрийн салбар	2017		2018		2018.I-XII 2017.I-XII"
	XII	I-XII	XII"	I-XII"	
Нийт дүн	1222495.5	8642954.0	2743356.7	10369607.3	120.0
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	176532.8	1267296.1	398028.7	1262477.6	99.6
Боловсруулах аж үйлдвэр	183633.4	1212288.8	1614741.3	3401426.8	280.6
Цахилгаан, дулаан эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	862329.3	6163369.1	730586.7	5705702.9	92.6

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2018 оны байдлаар 11.1 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулж өмнөх оны мөн үеэс 3.6 (47.2%) тэмбум төгрөгийн бүтээгдэхүүнээр өссөн байна.

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалт /сая төгрөг/



Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлийн 55 хувийг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж, 33 хувийг боловсруулах аж үйлдвэр, 12 хувийг уул уурхай, олборлох үйлдвэрлэл тус тус эзэлж байна.


Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл салбараар, 2018 оны жилийн эцсийн байдлаар, хувиар



Барилга

Барилга угсралт, их засварын 22.9 тэрбум төгрөгийн ажил хийж, үүнээс 20.1 тэрбум төгрөгийн шинэ барилга өргөтгөл шинэчлэлт, 2.7 тэрбум төгрөгийн барилга угсралт их засварын ажлыг гүйцэтгэсэн байна.

Алтай хотын төвд шинээр 960 хүүхдийн хүчин чадал бүхий сургуулийн барилга, 50 ортой төрөх эмнэлэг, 120 айлын орон сууц, Солонго хорооллын дулааны эх үүсвэр, АШУҮИС-ийн аймаг дахь салбар сургуулийн шинэ барилга, Цээл сумын Эрүүл мэндийн төвийн барилга, Тайшир сумын 75 хүүхдийн цэцэрлэгийн барилга зэрэг томоохон бүтээн байгуулалтууд ашиглалтанд орлоо.



Онцгой байдлын газар: Нийт 49 гал түймэр гарч 18 гал түймрийг иргэд өөрсдөө унтраасан бол 31 гал түймэрийг гал түймэр унтраах, аврах 59 дүгээр анги газар дээр нь ажиллаж унтраасан, 10.9 мянган айл өрх, 296 объектод урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт хийж, 380.2 сая төгрөгийн хөрөнгийг гал түймрээс аварсан байна.

Хүмүүсийн болгоомжгүй үйл ажиллагаанаас шалтгаалсан гал түймрийн улмаас 111.8 сая төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирсан байна.

Гамшиг, аюулт үзэгдлийн нийт 52 дуудлага ирж, 12 дуудлагад Онцгой байдлын газрын Эрэн хайх, аврах бүлэг ажилласан байна.

Мал амьтны гоц халдварт өвчний 38 удаагийн дуудлагад сумын онцгой комисс, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг ажиллуулж, мэргэжлийн удирдлагаар хангасан.

Газар хөдлөлтийн 2 удаагийн дуудлага ирж сумдад газар хөдөлсөн үед мэдээлэл цуглуулах ажлын хэсгийг ажиллуулж удирдлагаар хангасан.

Хүнс, хөдөө аж ахуйн газар: Цөм сүрэг бүхий 5277 толгой хонийг ээмэгжүүлэн бүртгэлжүүлж, үржлийн сүрэгт 8829, хэрэгцээний сүрэгт 1894 толгой хонийг, мөн 3 сумын 6 багийн 7.0 мянган тэмээнд үзлэг ангилалт хийж цөм сүрэгт 120 буур, 1105 ингэ нийт 1225 тэмээг, үржлийн сүрэгт 4763 ингэ, хэрэгцээний сүрэгт 1012 ингийг хамруулжээ. Улсын төсвийн 64.0 сая төгрөгийн хөрөнгөөр бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг 10.0 мянган га талбайд, Баян-Уул сумын нутаг дэвсгэрт тухайн сумын нутгийн зөвлөлийн 4.5 сая төгрөгийн хандиваар 400 га талбайд үлийн цагаан оготнотой микробиологийн аргаар тэмцэх ажлыг хийсэн байна. Улсын төсвийн 79 сая төгрөгийн хөрөнгөөр 20.0 мянган га, талбайд бэлчээрийн хөнөөлт царцаатай тэмцэх ажлыг зохион байгуулжээ.

Төрийн аудитын газар: Санхүүгийн тайлангийн аудит 218, нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн 5, нийцлийн 3, өөрийн санаачилгаар гүйцэтгэлийн 2, нийцлийн 3 аудитыг 3 ахлах аудитор, 6 аудиторовын хүчин чадлаар 3205 хүн өдөр, 5615 илүү цагаар ажиллан хийж гүйцэтгэжээ. 2018 онд хийсэн аудитаар 112.5 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж аудитын явцад 4.9 тэрбум төгрөгийг залруулж, 65.9 тэрбум төгрөгийн зөрчилд 286 албан тушаалтанд зөрчил арилгуулах албан шаардлага, 38.5 тэрбум төгрөгийн зөрчилд 85 заалт бүхий зөвлөмж өгч, 3.0 тэрбум төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоожээ.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар: Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу аймгийн хэмжээнд 2018 онд 18 сумын 1693 иргэнд 122.5 га газрыг гэр

бүлийн хэрэгцээний зориулалтаар үнэ төлбөргүй өмчлүүлэхээр төлөвлөснөөс 16 сумын 675 иргэнд 50.9 га газрыг өмчлүүлсэн ба төлөвлөгөөний биелэлт 40 хувьтай байна.

Төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд зориулан 11 суманд 43 нэгж талбар 18275.5 га газрыг төлөвлөснөөс 9 сумын 40 нэгж талбар 18265.3 га газрыг эзэмшүүлсэн ба төлөвлөгөөний биелэлт 93 хувьтай байна. Энэ онд Есөнбулаг сум 205 иргэнд 16.2 га газрыг, Эрдэнэ сум 160 иргэнд 11.2 га газрыг Цогт сум 76 иргэнд 5.7 га газрыг өмчлүүлжээ.

АШУУИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар сургууль: Энэ хичээлийн жилд 56 үндсэн багш, 10 гэрээт болон цагийн багш, 29 ажилтан, 930 оюутан, 46 сурагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Анагаахын ангид 305, сувилахуйн ангид 106, эх барихуйн ангид 44, эрүүл мэндийн нийгмийн ажилтны ангид 7, сувилагч 165, эх баригч 40, эм найруулагч 80, уламжлалт анагаахын сувилагч 28, лабораторийн техникч 44, туслах сувилагчийн ангид 21 оюутан тус тус суралцаж байна. Сувилахуй, эх барихуйн шаталсан сургалтаар 290 оюутан суралцаж байна.

Орон нутгийн өмчийн газар: Худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөө 2018 оны 4 дүгээр улирлын байдлаар 17 466.4 сая төгрөгийн 65 төсөл арга хэмжээг төлөвлөж худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна. Үүнээс: Улсын төсвийн хөрөнгөөр бараа 4, ажил 26 нийт 30 төсөл арга хэмжээнд 12.9 тэрбум төгрөг, орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа 5, ажил 5, зөвлөх 1, нийт 10 төсөл арга хэмжээнд 2.6 тэрбум төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бараа 5, ажил 6, нийт 11 төсөл арга хэмжээнд 1.1 тэрбум төгрөг, өвсний үндэс хөтөлбөрийн санхүүжилтээр 1 ажилд 206.8 сая төгрөг, орон нутгийн замын сангийн хөрөнгөөр 8 ажилд 309.2 сая төгрөг, байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр ажил 1, зөвлөх үйлчилгээ 1 нийт 2 төсөл арга хэмжээнд бараанд 54.0 сая төгрөг, Гамшгийн сангийн хөрөнгөөр 2 барааны 99.1 сая төгрөг тус тус батлагдсан байна.

Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг төсөл арга хэмжээний явцад харьцуулбал гэрээ байгуулах эрх олгосон 60 төсөл арга хэмжээ 92.3 хувь байна. Үнэлгээний шатанд 2 төсөл арга хэмжээ 3.1 хувь, зарласан 3 төсөл арга хэмжээ 4.6 хувийг тус тус эзлэж байна.

Худалдан авах ажиллагааны цахим системээр 65 төсөл арга хэмжээ төлөвлөгдөж 65 тендер шалгаруулалтыг зохион байгуулж байна. Үүний 64 төсөл арга хэмжээг цахим хэлбэрээр, 1 төсөл арга хэмжээг эрх шилжүүлэн зохион байгуулсан уламжлалт хэлбэрээр, зохион байгуулж байна.

Зохион байгуулж байгаа 65 төсөл арга хэмжээнд харьцуулбал 64 төсөл арга хэмжээ буюу 98.5 хувийг цахим хэлбэрээр зохион байгуулжээ. Гэрээ байгуулсан 60 төсөл арга хэмжээнд 696.0 сая төгрөгийн хэмнэлтийг улс, орон нутгийн төсөвт гаргасан байна.

Өмч хувьчлалын орлогоос 46.0 сая төгрөг, түрээсийн орлогоос 28.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэн ажиллажээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын газар: Байгалийн дурсгалт Ээж хайрхан уулыг түшиглэж, Говийн их дархан цаазат газрын “А” хэсгийн захиргаатай хамтран явган аялал зохион байгуулсан ба нийт 200 гаруй аялагч оролцлоо. Дэлхийн цоохор ирвэсийг өдрийг тохиолдуулан уламжлал болгон зохион байгуулдаг “Ирвэсийн эх нутаг-2018” фестивалийг зохион байгуулж 100 гаруй сурагч, багш нар оролцсон. Аймгийн Засаг даргын А/438 тоот захирамжаар томилогдсон ажлын хэсэг Бигэр, Тайшир, Дэлгэр, Хөхморьт сумд ажиллаж нийт 25 га ойн зурвас байгуулах ажлын гүйцэтгэлтэй танилцаж ажлын гүйцэтгэл 75-80 хувийн амьдралттай байна дүгнэлт өгч ажиллаа.

Биеийн тамир, спортын газар: Нийтийн биеийн тамирын арга хэмжээний хүрээнд 26 тэмцээн уралдаан арга хэмжээ зохион байгуулагдсан ба давхардсан тоогоор 3398 тамирчин оролцсон байна. Үндэсний спортын VI их наадам 4 төрлөөр зохион байгуулагдаж 48 тамирчин оролцсон.

Баруун бүсийн аврага шалгаруулах волейболын тэмцээнд 75 тамирчин оролцож 8 алт, 19 мөнгө, 26 хүрэл, улсын аварга шалгаруулах тэмцээнд 13 төрлөөр 192 тамирчин оролцож шатар 1 алт, таеквондо бага нас 7 алт, 6 мөнгө, 13 хүрэл, жүдо бөх 3 хүрэл, самбо бөх 2 хүрэл, хөнгөн атлетик, чөлөөт бөх, үндэсний бөх тус бүр 1 хүрэл медаль авсан байна. Өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээний 12 төрөл, насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээний 6 төрөл нэрэмжит тэмцээн 6 төрлөөр зохион байгуулан 5084 тамирчин хамрагдсан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба: 2018 онд 255 гүйцэтгэх хуудасны 2 тэрбум 45.3 сая төгрөгийн төлбөрийн үлдэгдэл дээр шүүхээс 388 гүйцэтгэх хуудасны 1 тэрбум 534.0 сая төгрөгийн төлбөр, харьяаллын дагуу 6 гүйцэтгэх хуудасны 45.5 сая төгрөгийн төлбөрийг, тус тус шинээр авч, 9 гүйцэтгэх хуудасны 88.9 сая төгрөгийн төлбөрийг төлбөр авагчид буцааж, 8 гүйцэтгэх хуудасны 25.4 сая төгрөгийг харьяалалын дагуу шилжүүлж 632 гүйцэтгэх хуудасны 3 тэрбум 510.5 сая төгрөгийн төлбөрийг биелүүлбэл зохихоос 329 гүйцэтгэх хуудасны 1 тэрбум 72.3 сая төгрөгийн төлбөрийг бодитойгоор биелүүлж 303 гүйцэтгэх хуудасны 2 тэрбум 438.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй, гүйцэтгэх хуудасны 52.1 хувийг бодитойгоор биелүүлсэн.


Хүүхдийн тэтгэлэг төлөх 142 төлөгчөөс 83.1 сая төгрөгийн тэтгэлэг гаргуулахаас 7 тэтгэлэг төлөгчийн хаягийг тодруулан 7.3 сая төгрөгийн тэтгэлэгийг харьяаллын дагуу шүлжүүлж, 1 тэтгэлэг төлөгчийн 0.6 сая төгрөгийг тэтгэлэг авагчийн хүсэлтээр буцааж 134 тэтгэлэг төлөгчийн 88.5 сая төгрөгийн тэтгэлэгийг биелүүлэхээс 6 тэтгэлэг төлөгчийн 4.0 сая төгрөгийг бүрэн дуусгавар болгож 1 тэтгэлэгийн 0.3 сая төгрөгийн тэтгэлэг төлөгч нас барснаар дуусгавар болж, 2 тэтгэлэгийн 1.7 сая төгрөгийн тэтгэлэг авагч тэтгэлэг авахаас татгалзаж, 2 тэтгэлэг төлөгчийн 7.2 сая төгрөг тэтгэлэг авагчтай эвлэрснээр дуусгавар болж, 95 тэтгэлэг төлөгчийн 56.8 сая төгрөгийг хэсэгчлэн биелүүлж 123 тэтгэлэг төлөгчөөс 18.5 сая төгрөгийн тэтгэлэгийн үлдэгдэлтэй байна.

Хорих ангид ял эдлэж байгаа 15 ялтны шүүхээс 91 гүйцэтгэх хуудасны 136.9 сая төгрөгийн төлбөр хохирол гаргуулахаас хорих ялаас хугацаа дуусч 4 хоригдолын 36 гүйцэтгэх хуудасны 82.8 сая төгрөг хасагдаж, 1 хоригдолын 1 гүйцэтгэх хуудасны 1.0 сая төгрөг харьяалалын дагуу шилжүүлж, 9 гүйцэтгэх хуудасны 2.7 сая төгрөгийн төлбөрийг бодитойгоор гаргуулж, 45 гүйцэтгэх хуудасны 50.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй ажилласан.

Холбооны газар


Суурин телефон цэгийн тоо 576 холбоо ашиглалтын орлого 288.3 сая төгрөг, үүнээс хүн амаас орсон орлого 201.8 сая төгрөг болжээ. Интернетийн үйлчилгээний нэг цэгийн 15 суудалтай интернетээр дунджаар 1080 хүнд үйлчилжээ.

Харилцаа холбооны үйлчилгээний орлого сая төг



■ 2017 оны XII сард ■ 2018 оны XII сард

Суурин утасны цэгийн тоо



■ 2017 оны XII сард ■ 2018 оны XII сард

Говь-Алтай аймгийн 2019 оны I-III сарын цаг агаарын урьдчилсан төлөв

Хоёрдугаар сард. Уур амьсгалын дунджаар агаарын температурын сарын дундаж нь Говь-Алтайн өмнөд хэсэг 6-14 градус, бусад нутгаар 15-20 градус хүйтэн байдаг. Ихэнх нутгаар 1.5 мм хүртэл цас ордог.

2019 оны 2 дугаар сард агаарын дундаж температур Говь-Алтайн ихэнх нутгаар дунджийн орчим байх төлөвтэй (**9 дүгээр зураг**).



Говь-Алтайн өмнөд хэсгээр уур амьсгалын дунджаас ахиу, бусад нутгаар дунджийн орчим хур тунадас орох төлөвтэй (**10 дугаар зураг**).



Гуравдугаар сард. Уур амьсгалын дунджаар агаарын температурын сарын дундаж нь Говь-Алтайн өмнөд хэсгээр 4 градус хүйтнээс 2 градус дулаан, бусад нутгаар 5-10 градус хүйтэн байдаг. Говь-Алтайн баруун хэсгээр 0.4-2.5 мм, бусад нутгаар 2.5-5 мм хүртэл цас ордог.

2019 оны 3 дугаар сард агаарын дундаж температур Говь-Алтай ихэнх нутгаар уур амьсгалын дунджаас 0.5-1.5 градусаар дулаан, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй (**11 дүгээр зураг**).



Говь-Алтайн ихэнх нутгаар уур амьсгалын дунджаас бага, бусад нутгаар уг дунджийн орчим хур тунадас орох төлөвтэй (**12 дугаар зураг**).



2018 оны 5-6 дугаар сард ихэнх нутгаар хүчтэй халж, бороо хур харьцангуй бага орсны улмаас бэлчээрийн ургамлын ургалтын байдал нутгийн 30 орчим хувьд дунд зэрэг, 40 орчим хувьд муу буюу гантай байсан бол 7 дугаар сар гарсаар ихэнх нутгаар бороо их орж, нутгийн 70 хувьд, 8 дугаар сарын 20-ны байдлаар 90 орчим хувьд зуншлага сайжирч, зөвхөн нутгийн 10 орчим хувьд муу байв.

Хүйтний улирлын цаг агаарын урьдчилсан төлөвөөр агаарын температур баруун аймгуудын нутгийн өмнөд, говийн аймгуудын ихэнх нутгаар уур амьсгалын дунджаас 0.5-1.5 градус дулаан, бусад нутгаар дунджийн орчим, зөвхөн хүйтний улирлын дунд үеэр төвийн аймгуудын нутгийн хойд хэсгээр дунджаас бага зэрэг хүйтэн байх төлөвтэй.

Хур тунадас улирлын эхэн болон сүүлчээр Алтайн өвөр говь, говийн аймгуудын нутгийн зүүн хэсгээр уур амьсгалын дунджаас бага орох төлөвтэй бол X сард Увсын нутаг, Хөвсгөлийн зүүн, Архангай, Булган, Сэлэнгэ, Хэнтийн хойд хэсгээр, XI, XII сард баруун аймгуудын нутгийн хойд, төв болон зүүн аймгуудын нутгаар, 2019 оны I сард баруун ба зүүн аймгуудын нутгийн өмнөд, говийн аймгуудын нутгаар, II, III сард төв болон зүүн аймгуудын зарим нутгаар уур амьсгалын дунджаас ахиу орох төлөвтэй байна.

Өнгөрсөн зуны бэлчээрийн ургамлын ургалт, зуншлагын байдал дээр тулгуурлан 2018-2019 оны өвөл, хаврын бэлчээрийн даацыг тодорхойлсон мэдээгээр нутгийн 60 гаруй хувьд мал өвөлжилт, хаваржилт хэвийн байх боломжтой, харин 40 шахам хувьд өөрийн сумын нутагт мал сүргээ онд оруулах бэлчээрийн хүрэлцээ муу байгаа болон цас ахиу орох нутгуудад отор нүүдэл хийх, хадлан тэжээл бэлтгэх, татаж байршуулах ажлыг цас орж, цасан бүрхүүл тогтох, уул даваа хаагдах, хүйтрэхээс өмнө эртнээс оновчтой зохион байгуулах шаардлагатай болно.



**Нутаг дэвсгэр,
Засаг захиргааны
НЭГЖ**

Говь-Алтай аймгийн байршил




Баруун бүсийн таван аймаг нь 2017 онд нийтдээ 91 сумтай, 476 баг хороотой нийт нутаг дэвсгэрийн хэмжээ 415.3 мянган км квадрат ба хүн амын нягтшил 1 хүнд нэг кв.км-т байгаа нь бусад бүсүүдийн үзүүлэлтүүдтэй харьцуулахад ойролцоо байна. Харин төвийн бүс болон Улаанбаатар нийслэлээсээ Баян-Өлгий аймаг 1709 км, Баянхонгор аймаг 639 км, Говь-Алтай аймаг 1037 км, Завхан аймаг 1023 км, Ховд аймаг 1487 км, Увс аймаг 1417 км хол оршдог нь бусад бүсээс ялгаатай ба говь, хангай хосолсон өргөн уудам нутагтай далайн түвшнөөс дээш 721-4070 метр өндөрт оршдог.

Засаг захиргааны нэгж, тэдгээрийн нутаг дэвсгэр, замын урт

Засаг захиргааны нэгж

№	Сумын нэр	Сумын төвийн баг	Багийн тоо	Нутаг дэвсгэрийн хэмжээ км2	Алслалт километр	
					Улаанбаатар-аас	Аймгийн төвөөс
	БҮГД		87	141447	-	-
1	Алтай	Баян овоо	4	20256	1319	318
2	Баян-Уул	-	6	5836	1112	146
3	Бигэр	-	5	3826	961	108
4	Бугат	Баян гол	5	9921	1204	219
5	Дарив	Үйлдвэр	4	3523	1187	212
6	Дэлгэр	Баянсан	5	6625	913	88
7	Жаргалан	-	3	3683	1047	102
8	Тайшир	-	3	3913	991	43
9	Тонхил	-	5	7322	1210	218
10	Төгрөг	-	5	5343	1149	148
11	Халиун	-	4	5214	1056	87
12	Хөхморьт	Сайн уст	5	6314	1182	215
13	Цогт	-	7	16618	1040	187
14	Цээл	-	4	5631	1136	167
15	Чандмань	-	4	4629	955	189
16	Шарга	Баянгол	4	5566	1080	79
17	Эрдэнэ	-	4	25066	989	223
18	Есөнбулаг	-	10	2161	1037	-

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ГАЗАР ЗҮЙН БАЙРЛАЛ



Говь-Алтай аймгийн нутаг дэвсгэр, засаг захиргааны хуваарь

	Хэмжээ
Нутаг дэвсгэр /мян.км2/	141.4
Хилийн урт /км/	2040
Өмнөт цэгээс хойд цэг хүртэлх зай /км/	638
Баруун цэгээс зүүн цэг хүртэлх зай /км/	413
Монгол улсын нийт нутаг дэвсгэр /мян.км2/	1564.9
Монгол улсын нэг аймагт ногдох нутаг дэвсгэрийн дундаж /мян.км/	74.3
